



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Засгийн газарт чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг.Уул уурхайн салбарт газрын дор болон хүнд, хортой нөхцөлд ажиллаж буй иргэдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

1.1.Дараах чиглэлээр судлан шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулах;

1.1.1.өндөр насны тэтгэвэр тогтоох хувь хэмжээг нэмэгдүүлэх;

1.1.2.газрын дор ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдэд тэтгэврийн нэмэгдэл олгох;

1.1.3.Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт заасны дагуу төрөөс олгох нөхөн төлбөрийн давтамж, хувь хэмжээг тодорхой болгох;

1.1.4.нийгмийн даатгалын санд дээрх нөхөн төлбөр, нэмэгдлийг санхүүжүүлэх хуримтлал /сан/ бий болгох.

1.2.Налайхын уурхайд ажиллаж байх үедээ хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.4 дэх хэсэгт заасны дагуу нэг удаагийн нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шуурхай шийдвэрлэх.

Хоёр.Тогтоолын биелэлтийг 2014-2015 оны намрын чуулганы хугацаанд багтаан зохион байгуулж, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Засгийн газарт /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Р.БУРМАА